**ХОВД АЙМГИЙН УЦУОШТӨВИЙН “ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО”-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭХНИЙ ҮЕ ШАТНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ**

2025-05-26.

| Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан зорилт | Дугаар | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Зорилтот түвшин, үр дүн хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр | | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2025 оны эхний хагас жилд | | |
| | | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин үр дүн | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| Зорилт 5.1.Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад дорвитой хувь нэмэр оруулах зорилгоор "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг үр дүнтэй өрнүүлж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ. | | | | | | | | |
| 5.1.1 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намар заагдсан газарт мод тарих. | 1 | Томоохон хот, суурин газруудад мод тарьж, арчилж ургуулах боломжийг бүрдүүлнэ. | 2025 | УЦУОШТ | - | Хүрээлэн буй орчны ногоон байгууламж нэмэгдэж, байгууллагын өнгө үзэмж сайжирна. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2025 оны 44-р зарлиг ”Тэрбум мод тарих үндэсний өдөр зарлах тухай„ 2021 оны 178 дугаар ”Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Ховд аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн ажилчид 2025 оны 05 сарын Бямба, Ням гаригуудад өөрийн эзэмшлийн газар болон ойр орчмын газруудад хаврын цэнэг усалгаа хийж, зүлэг, цэцэг тарьж, модоо будаж шохойдсон. | 100% |
| 5.1.2 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд төвийн гадан талбайд ургаж байгаа | 2 | Төвийн гадан талбайд ургаж байгаа улиас модноос мөчир, харандааг мэргэжлийн | 2025 | “Ой анги” , “Үр жимс хоршоо” ХХК | - | Улиас модноос мөчир, харандааг бэлдэх | Төвийн гадан талбайд ургаж байгаа улиас модноос мөчир, харандааг ойн анги болон “Үр жимс хоршоо” ХХК мэргэжилтэндүүд бэлдэн авсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| улиас модноос мөчир, харандааг мэргэжлийн байгууллагууд-аар бэлдүүлэх. | | байгууллагууд-аар бэлдүүлэх. | | | | | |
| **Зорилт 5.2. Усны нөөцийг хамгаалж, хүн амыг баталгаат ундны усаар хангах, бэлчээрийг усжуулах, говийн бүс нутгийн усан хангамжийг нэмэгдүүлэх, саарал усыг дахин ашиглах, хиймэл нуур, хөв цөөрөм байгуулж, ширгэсэн гол горхи, булаг, шандыг нөхөн сэргээнэ.** | | | | | | | |
| Усны нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах бодлого хэрэгжүүлж байгууллагын цэвэр усны хэрэглээн хяналт тавих. | 3 | Төвий цэвэр усны хэрэглээн хяналт тавих | 2025 | УЦУОШТ | - | Төвий цэвэр усны хэрэглээн хяналт тавих | Усны нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах бодлого хэрэгжүүлж байгууллагын цэвэр усны хэрэглээнд хяналт тавин ажиллаж байна. | 100% |
| Зорилт 5.4.Эдийн засаг, аж үйлдвэржилтийн сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэхдээ байгаль хамгаалах үндэсний уламжлалт ёс заншлыг хадгалж, дэлхийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн ногоон хөгжлийн жишиг загварыг тодорхойлно. | | | | | | | | |
| 5.4.1 Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах, хүн амын эрүүл, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор агаар, ус, шинжилгээг хийх. | 4 | Орчны бохирдолт хянах | 2025 | УЦУОШТ | Улсын төсвөөс | Байгаль орчны хяналт, шинжилгээ сайжирсан байна. | Ховд аймгийн Агаарын хүхэрлэг хийн 358 сорьц, азотын давхар ислийн 358 сорьц, PM2.5 тоосны мэдээг өдөр бүр буюу 182 удаа авч нийт 898 дээжинд шинжилгээг хийж агаарын чанарыг хянасан.<br>Гадаргын усны 17 дээжинд 20 үзүүлэлтээр нийт 340 удаа, хаягдал бохир усны 12 дээжинд 4-9 үзүүлэлтээр нийт 78 шинжилгээ хийж дүн мэдээг мэдээллийн санд тухай бүр нь байршуулсан. | 100% |
| 5.4.2 Байгаль орчин, аялал | 5 | Агаар бохирдуулж | 2025 | Аймгийн ЗДТГазар, | Орон нутгийн төсвөөс | Агаар бохирдуулагч эх үүсвэрийн | Монгол Улсын “Агаарын тухай” хуулийн 8 дугаар | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| журулчлалын сайдын 2018 оны 11 сарын 30-ний өдрийн А/479 тоот тушаал, Ховд аймгийн Засаг даргын захирамжийн дагуу сумуудад агаар бохирдуулах эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийн ажлыг хийх. | | байгаа суурин ба хөдөлгөөнт эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл хийх. | | БОАЖГ, УЦУОШТ | | тооллогыг 16 сум, аймгийн 12 багийн нутаг дэвсгэрт зохион байгуулах, мэдээллийн сан үүсгэх, тайлан мэдээг хүргэх. | зүйлийн 8.1.4, 8.1.5 дахь заалт, Байгаль Орчин Аялал Жуулчлалын сайдын 2018 оны 11 дугаар сарын 30-ны өдрийн А-479 тоот журмын дагуу Ховд аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 03-ний өдрийн А/85 тоот захирамжаар байгуулсан ажлын хэсгийг бүрэлдэхүүн нь Ховд аймгийн хэмжээнд агаар бохирдуулж байгаа эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийн тооллогыг 2024 оны 12 дугаар сарын 03-наас 2025 оны 02 дугаар сарын 11-ний хооронд зохион байгуулж, дүнг нэгтгэн цахим санд бүртгэх ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэв. Аймгийн засаг даргын захирамжаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн нь хяналтын тооллогын үйл ажиллагааны зардалд 6.300.000 төгрөгийн санхүүгийн зардлыг орон нутгаас шийдвэрлүүлж "Булган, Үенч, Алтай, Мөст, Цэцэг, Дарви, Зэрэг, Манхан, Ховд, Эрдэнэбүрэн, Буянт, Мянгад, Дөргөн, Чандмань" гэсэн 14 суманд ажиллаж, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тухайн сумын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд арга зүйн зөвлөгөөг өгч хяналтын тооллогыг хамтран хийсэн | |
| **ЗУРГАА.ТӨРИЙН БҮТЭЭМЖИЙН СЭРГЭЛТ** | | | | | | | | |
| **Зорилт 6.1.Төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн хүнд суртлыг бууруулна.** | | | | | | | | |
| 6.1.1 Төрийн үйлчилгээний хүнд суртал, алдаа дутагдал, технологийн зөрчил гаргасан ажилтан албан хаагчдын үйл ажиллагаанд газар дээр нь хяналт шалгалт, үнэлгээ хийн шаардлагатай бол холбогдох хууль дүрэм, журмын дагуу хариуцлага тооцож, ажлыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ | 6. | Хөдөө цаг уурын өртөө, харуулуудын шинжилгээний ажил сайжирна. | 2025 | УЦУОШТ | Улсын төсвөөс | Чандмань, Зэрэг суманд цаг уурын автомат станц суурилуулах, шалган туслах хийх. | Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны хэрэгжүүлж буй "Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II,III төсөл"-ийн санхүүжилтээр Ховд аймгийн Чандмань, Зэрэг сумдад Финлянд улсын Vaisala үйлдвэрийн AWS-310 цаг уурын хэмжлийн бүрэн автомат станцыг суурилуулах ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 21-24-ний өдрүүдэд хийж, суурилуулах үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж, шинжилгээ судалгааны ажлын тасралтгүй байдлыг хангуулан улсын сүлжээнд холбосон. | 100% |
| **Зорилт 6.4.Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулна.** | | | | | | | | |
| 6.4.1 Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр байнгын хэрэгцээтэй бараа, ажил, | 7. | Тендерийн үйл ажиллагаа хялбар, хүртээмжтэй болгох. | 2025 | УЦУОШТ | Улсын төсвөөс 19.9 сая төгрөг | Тендерийн үйл ажиллагаа хялбар, хүртээмжтэй болно. | Энэ онд төвийн конторын барилгын дотор сантехникийн засварт 19.9 сая төгрөгний хөрөнгө оруулалт тавигдсан. Энэ ажлын хүрээнд тухайн чиглэлээр үйл ажиллагаа | 50% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| үйлчилгээг худалдан авах гэрээ, үнэ болон бусад нөхцөл тендерийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй, шуурхай болгох | | | | | | | явуулдаг нэр бүхий 4 компанид үнийн санал ирүүлэх хүсэлт явуулж материалыг хүлээн авсан. Үнийн санал ирүүлсэн 4 компанийн материалыг төвийн даргын тушаалаар батлагдсан ажлын хэсгийн гишүүд хянан үзэж шалгарсан компанитай гэрээ байгуулж, ажлаа эхлүүлээд байна. Төвийн конторын барилгын сантехникийн ажил шууд худалдан авах гэрээгээр хийгдэж байна. | |
| **НИЙТ 7 АЖИЛ ТӨЛӨВЛӨЖ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ** | | | | | | | | **92.8 %** |

ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

БОШЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ, ЧАНАРЫН МЕНЕЖЕР С. Жавзанпагма С. ЖАВЗАНПАГМА



*5.1.1. Бүх нийтийн мод тарих өдөр*



5.1.2. Модноос мөчир, харандааг Ойн анги болон “Үр жимс хоршоо” ХХК бэлдэх



*5.4.2. Агаарын бохирдолтын эх үүсвэрийн тооллогыг 17 сумдад хийсэн*




6.1 Багаж суурилуулж байгаа нь